



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
бэлгэдлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйлийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийн тодорхойлолт, эх загварыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүүргийн бэлгэдлийг батлагдсан тодорхойлолт, загварын дагуу бүтээж, нийтэд сурталчлах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.



1150100010

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны 02 дугаар сарын 16-ны  
өдрийн... дугаар тогтоодын хавсралт



## Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийн тодорхойлолт, эх загвар



1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, хороод, харьяа байгууллагууд нь энэхүү баталсан загварын дагуу бүтээгдсэн бэлгэдлийг хэрэглэнэ.
2. Чингэлтэй хайрхан уулыг эрт үеэс эрдэм номын бэлгэ тэмдэг болгон хүндэтгэж ирсэн уламжлалыг харгалzan түүнийг хүслийг хангач Чандмань эрдэнээр төлөөлүүлэн дүрсэлнэ.
3. Чандмань эрдэнийг улаан, ногоон, хөх өнгийг todoos шингэрээж, гурваар дагнах бөгөөд улаан өнгийг дээд талд нь голлуулж, зүүн талд нь ногоон, баруун талд нь хөх өнгийг байрлуулна.
4. Бэлгэдлийн оройд үеийн үед нар мэт мандаж, сар мэт гийгүүлж, гал мэт дүрэлзэн бадарч байхыг бэлгэдэн нар, сар, галын дурсийг зална. Нар, сарыг шар өнгөөр, галыг улаан өнгөөр илэрхийлнэ.
5. Галыг төрийн соёмбо дээрх гал адилаар дүрсэлнэ.
6. Бэлгэдлийн суурьт эх дэлхий, газар нутгийнхаа ариун дагшин байдлыг чандлан хамгаалахыг бэлгэдэж цагаан өнгийн бадам цэцгийн дэлбээг голлуулан байрлуулна.
7. Бадам цэцгийн дэлбээн дунд нь Чингэлтэй хайрхны савдаг зэрлэг гахайн толгойг цухуйлган дүрсэлнэ.
8. Бадам цэцгийн толионд нь “Чингэлтэй дүүрэг” гэсэн бичвэрийг шар суурин дээр хөх өнгөөр голлуулан бичнэ.